



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 252

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн Ардчилсан намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн Ардчилсан нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817-1:2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817-6:2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817-8:2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030464

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## Дүгнэлт

Аймгийн Ардчилсан намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН



# ШИНЭ ӨВӨРХАНГАЙ

ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО **2020**



**ХҮН БҮРД ОРЛОГО  
ӨРХ БҮРД ӨСӨЛТ** ✓

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН АЙМАГ, СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020

**ШИНЭ ӨВӨРХАНГАЙ, ШИНЭ ХӨГЖИЛ  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт Ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, Ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох “**ШИНЭ ӨВӨРХАНГАЙ, ШИНЭ ХӨГЖИЛ**” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

**УРИА: ХҮН БҮРД ОРЛОГО – ӨРХ БҮРД ӨСӨЛТ  
НЭР: ШИНЭ ӨВӨРХАНГАЙ, ШИНЭ ХӨГЖИЛ**



## ГАРЧИГ

### НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ
- 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ
  - 1.3.1. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
  - 1.3.2. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
- 1.4. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

### ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- 2.1. ХЯМРАЛЫН ҮЕИЙН ОНЦГОЙ БОДЛОГО
- 2.2. ӨСӨЛТИЙН БОДЛОГО
  - 2.2.1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ
- 2.3. ТӨРӨЛЖИЛТИЙН БОДЛОГО
  - 2.3.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР
  - 2.3.2. ДЭД БҮТЭЦ
  - 2.3.3. ЭРЧИМ ХҮЧ
  - 2.3.4. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА
  - 2.3.5. БАРИЛГЫН САЛБАР
  - 2.3.6. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
  - 2.3.7. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

### ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- 3.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖИЛ
- 3.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ
  - 3.2.1. “ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР
  - 3.2.2. “ШИНЭ СУМ” ТӨСӨЛ
  - 3.2.3. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР
- 3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ
- 3.4. МАЛ АЖ АХУЙ
- 3.5. ГАЗАР ТАРИАЛАН

### ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- 4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

### ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

- 5.1. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ



## НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

### 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, Өвөрхангай нутгийнхаа байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, эх нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.
- 1.1.3 Архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажиллах ба архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, эрүүл идэвхтэй амьдралын клубыг аймаг, сум бүрт байгуулахыг дэмжинэ.
- 1.1.4 Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.1.6 Мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.
- 1.1.7 Амжилттай хэрэгжиж буй “Мянган инженер” хөтөлбөрт орон нутгийн залуучуудыг хамруулна.
- 1.1.8 Төрийн өмчийн оролцоотой соёлын байгууллагуудын санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх ба спорт клубуудыг амжилтаар нь дэмжинэ.
- 1.1.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авъяас, хөдөлмөр бүтээлийг дэмжиж ажиллана.
- 1.1.10 Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургахад орон нутгийн төсвийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлнэ. “Шинэ багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.11 Ерөнхий Боловсролын Сургуульд: Гадаад мэргэжилтэн, гадаад хэлний ахмад багш нарыг зөвлөхөөр ажиллахад дэмжлэг үзүүлнэ.



- 1.1.12 Аймгийн төвд “Спорт”-ын төрөлжсөн сургуулийг шинээр барина.
- 1.1.13 Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг авч, нийгмийн баталгааг нь эрс дээшлүүлнэ.
- 1.1.14 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд аймаг, сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.1.15 Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, бассейн, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагад хяналт тавина.
- 1.1.16 Хүн ам, албан хаагч, ажилчдын цахим боловсролыг дээшлүүлж, бүх нийтийн цахим боловсролыг (Digital Literacy) дээшлүүлнэ.
- 1.1.17 Арвайхээр суманд сургуулийн автобустай болно.

## 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨГС ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, урьдчлан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.


- 1.2.1 Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг дээшлүүлнэ.
- 1.2.2 Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн стандартыг хангуулах
- 1.2.3 Оношилгооны төв, хавдрын хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх төвийг барьж, байгуулна.
- 1.2.4 Аймгийн төвд “Мэс Засал”-ын эмнэлгийг шинээр барина.
- 1.2.5 Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгож, гэрийн эмчийн шинэ тогтолцоонд шилжинэ.
- 1.2.6 Хар тамхи, мансуурах бодист донтох, амиа хорлолтын шалтгаан, сэтгэл гутралын өвчлөл, хамаарлын болон бусад сэтгэцийн эмгэг өвчнийг эрт илрүүлж, эмчлэх, нөхөн сэргээх үйлчилгээг бий болгоно.
- 1.2.7 Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- 1.2.8 Өвөрхангай аймгийн нийт сумдын эмийн сангийн тоо хүртээмжийг нэмэгдүүлнэ.



- 1.2.9 Өрх, сумын эрүүл мэндийн төвийн залуу эмч нарын мэргэжил, боловсролыг хуулийн дагуу таван жил тутамд тасралтгүй дээшлүүлнэ.
- 1.2.10 Сонгон шалгаруулалтад тэнцсэн ерөнхий мэргэжлийн бакалаврын зэрэгтэй эмч нарыг резидентын сургалтад хамруулна.
- 1.2.11 Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулахыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.12 Эмчийн чадавх, эмчилгээний үр дүнг үнэлэх цахим систем ажиллуулж, сайн эмчийг сонгож үйлчлүүлэх өрсөлдөөнд суурилсан тусламж үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.2.13 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.
- 1.2.14 Эрүүл мэндийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх бөгөөд эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.
- 1.2.15 Өрх, сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг хүн амын шилжилт хөдөлгөөнтэй уялдуулна.
- 1.2.16 Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.17 Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, тарималжуулж, үржүүлнэ. Үндэсний эм, эмнэлгийн хэрэгслийн дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжинэ.
- 1.2.18 Шаардлагатай сумдад эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийнэ.

### 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ

- 1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.
- 1.3.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.3 Өвөрхангай аймгийн бүх сумдад залуучуудийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх төвтэй болно.
- 1.3.4 Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийж, “Эрүүл хэргэс” төслийг хэрэгжүүлнэ.



*(Handwritten signature)*



- 1.3.6 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
- 1.3.7 Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 1.3.8 Хот байгуулалт, барилга, нийгэм, соёлын байгууламжийн төлөвлөлтөд нийт иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийг бий болгоно.
- 1.3.9 Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санаачилга, манлайллыг дэмжинэ.
- 1.3.10 Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

### **1.3.1. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

- 1.3.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.3.1.2 Төрийн үйлчилгээний байгууллагуудад дутагдалтай байгаа хүний нөөцийг бодлогоор дэмжинэ.
- 1.3.1.3 Гадаадад ажиллах хүч гаргах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, хамтарч ажиллана.
- 1.3.1.4 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- 1.3.1.5 Гарааны бизнес буюу "Старт-Апп"-ыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

### **1.3.2. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

- 1.3.2.1 Ахмадын өдөр өнжүүлэх төвүүдийг бий болгож хөгжүүлнэ.
- 1.3.2.2 Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.2.3 Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын нийгмийн асуудалд онцгой анхаарч, өрхийн эмнэлгүүдийн санхүүгийн бие даасан үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 1.3.2.4 Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- 1.3.2.5 Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. НАМ

### **1.4. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ**

Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна.

- 1.4.1 Соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгоно.




- 1.4.2 Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнтэй өвийг хөгжүүлнэ.
- 1.4.3 Үндэсний агуулга бүхий кино, тайз, дэлгэцийн бүтээлийг хөгжүүлж, дэмжинэ. Тайз, дэлгэцийн үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж, түүх, соёлын агуулга бүхий контентыг үзэгчдэд хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.4 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчилж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагчтай байх тогтолцоог бий болгоно.
- 1.4.5 Төрийн өмчийн оролцоо бүхий соёлын байгууллагуудын бие даасан байдал, санхүүгийн эрх чөлөөг нэмэгдүүлнэ.
- 1.4.6 Мэргэжлийн урлагийн сургалтын байгууллага төгсөгч, дадлагажигчдад эзэмшсэн ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход нь дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.7 Биеийн тамир, спортын салбарт аюулгүй ажиллагааны талаар шаардлагатай стандартуудыг нэвтрүүлнэ.
- 1.4.8 Спорт цогцолбор, бассейн, сургалтын төв, чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх багтаамж ихтэй байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 1.4.9 Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.10 Олимпын олон төрлөөр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний хэмжээний тэмцээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, спорт клубүүдийг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.

## **ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**

### **2.1. ХЯМРАЛЫН ҮЕИЙН ОНЦГОЙ БОДЛОГО**

Дэлхий нийтийг хамарсан (КОВИД-19) цар тахлын тархалтаас шалтгаалж олон улсад эдийн засгийн түүхэнд байгаагүй маш ноцтой байдал үүсээд байна. Дэлхийн эдийн засаг 2020- 2021 онд уналтад орох төлөвийг олон улсын байгууллагуудаас 3 дугаар сарын байдлаар гаргасан байна. Монгол Улсын эдийн засгийн гол бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ мөн уналтад ороод байна. Иймд дараах арга хэмжээнүүдийг орон нутагт хэрэгжүүлнэ.

- 2.1.1 Төсвийн хэмнэгдсэн зардлыг иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ажлын байрыг хадгалсан болон нэмэгдүүлсэн аж ахуй нэгжийг дэмжинэ.



- 2.1.2 Сум хөгжүүлэх сангийн зээлийг иргэдэд тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүйгээр олгоно.
- 2.1.3 Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг жил бүр тогтвортойгоор нэмэгдүүлэн, үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй хүргэнэ.

## **2.2. ӨСӨЛТИЙН БОДЛОГО**

- 2.2.1 Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход түлхүү чиглүүлэх бодлого баримтална.
- 2.2.2 Арвайхээр, Хархорин суманд тээвэр ложистикийн төв байгуулна.
- 2.2.3 Сум бүрийн онцлогт тохирсон Брэнд бүтээгдэхүүн бий болгоход ЖДҮ-ийн бодлогоор дэмжинэ.
- 2.2.4 Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.
- 2.2.5 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийн хөрөнгө оруулалтын анхны санхүүжилтийг бодлогоор дэмжинэ.

### **2.2.1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ**


- 2.2.1 Ядуурлын түвшинг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал Алсын хараа-2050 бодлогын баримт бичигт заасан түвшинд хүргэж бууруулна.
- 2.2.2 Эрдэс баялгийн, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
- 2.2.3 Төрийн албанаас эрт тэтгэвэртээ гарч жижиг дунд, бичил бизнесийн салбарт шилжин баялаг бүтээх иргэдээ эдийн засгийн бодлогоор дэмжинэ.

### **2.3. ТӨРӨЛЖИЛТИЙН БОДЛОГО**

- 2.3.1 Арвайхээр-Хужирт-Бат Өлзий чиглэлийн авто зам барина.
- 2.3.2 Арвайхээр- Баянголыг холбон хатуу хучилттай зам барих
- 2.3.3 Баянтээгт 36МВт-ийн дулааны цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

#### **2.3.1. АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР**

- 2.3.1.1 Хөдөө аж ахуйн салбарт боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс ширний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.



2.3.1.2 Уул уурхайн салбарт нөхөн сэргээх шаардлагатай газруудад иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.

### **2.3.2. ДЭД БҮТЭЦ**

2.3.2.1 Орон нутгийн авто замын сүлжээг бий болгоно. /Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Богд, Бүрд, Гучин-Ус, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Өлзийт, Сант, Төгрөг, Хайрхандулаан, Хархорин сумдын төвийг хямд өртөгтэй авто замаар аймгийн төвтэй нь холбох ажлыг эхлүүлнэ./

### **2.3.3. ЭРЧИМ ХҮЧ**

2.3.3.1 Аймгийн төвд дулааны станц, дулааны сүлжээ байгуулах ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулна.

2.3.3.2 Шинэ бүтээн байгуулалт, шинэ суурьшлын бүс, хот суурин газрыг дулааны эрчим хүчээр найдвартай хангах техник, технологийн боломжийг бүрдүүлнэ.

2.3.3.3 Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.

2.3.3.4 Өвөрхангай аймгийн бүх сумдын эрчим хүчний найдвартай байдлыг хангах

### **2.3.4. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА**

2.3.4.1 Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ.

2.3.4.2 Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг нэвтрүүлнэ.

2.3.4.3 Иргэдэд зориулсан цахим боловсролын төвүүдийг байгуулна.

### **2.3.5. БАРИЛГЫН САЛБАР**


2.3.5.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлэх замаар хөрсний бохирдлыг эрс бууруулна.

2.3.5.2 Зохион байгуулалттай хөдөлмөр зуучийн үйлчилгээг дэмжих замаар цагийн ажлын тогтолцоог дэмжинэ.

### **2.3.6. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

2.3.6.1 Спортын, эрүүл мэндийн, эко-туризмын, нүүдэлчний өв соёлоо сурталчлах зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг хөхүүлэн дэмжинэ.

2.3.6.2 Говь болон хангайн бүсийн аялал жуулчлалын маршрутад холбоно. /Говийн бүс: Баянгол-Төгрөг-Богд-Баруунбаян-Улаан, Хангайн бүс: Уянга-Бат-Өлзий-Хужирт-Хархорин/



- 2.3.6.3 Жуулчлалаас орж ирэх эдийн засгийн орлогыг шинэчлэн төлөвлөж, орон нутгийн түвшинд салбаруудын хамтын ажиллагааг сайжруулах, аялал жуулчлалын талаарх Үндэсний бодлого, төлөвлөгөөг орон нутгийн төр захиргааны төлөвлөлтөд тусгана.
- 2.3.6.4 Орон нутгийн иргэд, олон нийтийн амьдралд сайнаар нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.3.6.5 Арвайн талд “Монгол Түмний Морины Их Шүтээн”-ийг аялал, жуулчлалын бүс болгоно.
- 2.3.6.6 Хархорин суманд Аялал, жуулчлалын цогцолборыг бий болгож хөгжүүлнэ.
- 2.3.6.7 Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлнэ.
- 2.3.6.8 Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогод тусгагдсан байгалийн онцгой үзэсгэлэнт газар, тусгай хамгаалалттай газруудад хэрэгжих олон улсын байгууллагын болон хувийн хэвшлийн санаачилгыг дэмжинэ. Хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдийг бодлогоор дэмжинэ.

### **2.3.7. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ**


- 2.3.7.1 Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 2.3.7.2 Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотооддоо хангахад чиглэгдсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.
- 2.3.7.3 Орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 2.3.7.4 Дөрвөн улирлын хүлэмжийн төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3.7.5 Экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуй-хөнгөн үйлдвэрлэлийн кластерийг аймгийн түвшинд хөгжүүлэхийг дэмжинэ.

## **ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ**

### **3.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖИЛ**

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах тэнцвэртэй хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилнэ.

- 3.1.1 Үүрэн телефоны бүх сүлжээний өргөтгөл, хүртээмжийг нэмэгдүүлэх
- 3.1.2 Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулах
- 3.1.3 Цэвэр бохирын усны шугам сүлжээнд холбогдоогүй сумдыг холбох



*(Handwritten signature)*

### 3.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ


- 3.2.1 Өвөрхангай аймгийн 19 сумын төвийн гэр хорооллын гудамжийг цэгцэлж, жишиг гудамжуудыг бий болгох
- 3.2.2 Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд орон нутгийн аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийг давуу эрхтэй оролцуулахыг дэмжиж ажиллана. ЭДИЙН ЗАСАГ
- 3.2.3 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загвар хөгжүүлэхийг дэмжинэ.

#### 3.2.1. “ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР

- 3.2.1.1 Түүхий эд үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэр, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан борлуулагч талууд корпорац болон кластерын тогтолцоогоор хамтран ажиллах загварыг дэмжинэ.
- 3.2.1.2 Бэлчээрийн менежментийг сайжруулна.
- 3.2.1.3 Хог хаягдлын менежментийг сайжруулна.
- 3.2.1.4 “Шинэ баг”-төсөл хэрэгжүүлнэ.
- 3.2.1.5 Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Бат-Өлзий, Баянгол, Гучин-Ус, Есөнзүйл суманд өвс тэжээлийн агуулах барина.
- 3.2.1.6 Уяачдын нийгмийн асуудалд онцгой анхаарч ажиллана.
- 3.2.1.7 “Морин”-спортын төрлийг хөгжүүлнэ.

#### 3.2.2. “ШИНЭ СУМ” ТӨСӨЛ

- Иргэдийн оролцоотой “ШИНЭ СУМ” төсөл хэрэгжүүлнэ.
- 3.2.2.1 Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн сууринг хөгжүүлнэ.
- 3.2.2.2 Сумын төвийг иргэдийн оролцоотой шинэчилнэ.
- 3.2.2.3 Сумын шинэчлэлийн төслийн хүрээнд сумдыг үе шаттайгаар шинэчилнэ.
- 3.2.2.4 Булаг шандны эхийг хамгаална.
- 3.2.2.5 Сумын төвийг камержуулах ажлыг стандартад нийцсэн камерын системтэй болгоно.
- 3.2.2.6 Төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь барих ажлыг дэмжинэ.
- 3.2.2.7 Онги, Дайргын гол, Дэлгэрэх булгийн дагуу түргэн ургацтай таримлын хүрээлэнг байгуулж, иргэдийн зуслан, амралтын газар байгуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.2.2.8 Арвайхээр, Тарагт, Уянга сумдыг хатуу хучилттай замаар холбох



- 3.2.2.9 Говийн сумдын ногоон байгууламж, цэцэрлэгжилтийг бодлогоор дэмжих
- 3.2.2.10 Ахмадын өдөр өнжүүлэх төвийг хөгжүүлэх
- 3.2.2.11 Уянга, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Богд сумдыг “Эрүүл-Хаус”, \жорлонгоо өөрчилье\ төсөл хэрэгжүүлэх
- 3.2.2.12 Уянга, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Богд сумдад Хүүхэд Залуучуудын төв байгуулах
- 3.2.2.13 Тарагт сумын Хүрэмтийн “Халуун рашаан”-ыг түшиглэн Аялал жуулчлал, маралт сувилалын төв байгуулан хөгжүүлэх.

### **3.2.3. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР**

- 3.2.3.1 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

### **3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ**

- 3.3.1 “Хариуцлагатай нүүдэлчид” хөтөлбөрийн хүрээнд малын гаралтай түүхий эдийг мөшгөх тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.3.2 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.
- 3.3.3 Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч амьтад болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавьжыг устгана.

### **3.4. МАЛ АЖ АХУЙ**

- 3.4.1 Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ. Иргэдийн санаачилгад суурилсан “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.4.2 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
- 3.4.3 Малын үүлдэр угсааг сайжруулна.
- 3.4.4 Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг орон даяар хэрэгжүүлнэ.
- 3.4.5 Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.




### 3.5. ГАЗАР ТАРИАЛАН

- 3.5.1 Үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, аж ахуйг сэргээн хөгжүүлж, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.5.2 Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- 3.5.3 Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийн тоог нэмэгдүүлнэ.
- 3.5.4 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.
- 3.5.5 Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.
- 3.5.6 Газрын үржил шимийг хамгаалан зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлнэ.
- 3.5.7 Тариалангийн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ газрын үржил шимийг хамгаалах, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн технологи, инновацын шинэчлэл хийж, "Ухаалаг газар тариалан" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.5.8 Таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцоор хөгжүүлж, үрийн сорт сорилт, чанарыг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нутагшсан сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.5.9 Орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 3.5.10 Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн техник хангамжийн түвшнийг дээшлүүлнэ.
- 3.5.11 Эрдэс болон органик гаралтай бордооны дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, хангамжийг нэмэгдүүлнэ.

### ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- 4.1.1 Мансууруулах, сэтгэгдэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч болсон хүнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд анхаарна.
- 4.1.2 Нас, хүйс, нийгмийн бүхий л давхаргад гарч буй улс төрийн үзэл баримтлал ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсоход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.



Handwritten signature and initials in black ink.



4.1.3 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургууль болон бусад бичил орчинд хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг ханган ажиллана.

#### 4.2. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

4.2.1 Арвайхээр, Хархорин сумдыг хотын статусаар хөгжих бололцоо, нөхцлөөр ханган ажиллана.

4.2.2 Төрийн албан тушаалтны хүнд суртлыг арилгаж, дарга нарын үрэлгэн зардал, тансаглалыг таслан зогсооно.

4.2.3 Орчин үеийн стандартын шаардлага хангасан архивын барилгыг шинээр барьж, архивын сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, архивын үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлыг шат дараатай авч хэрэгжүүлэн, архивын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх

4.2.4 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж уулзах боломжгүй иргэд төрийн захиргааны албан тушаалтан, албан хаагчидтай онлайнаар уулзах боломжийг бүрдүүлнэ.

4.2.5 Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний шийдвэрийг шилэн болгож ажиллана.


4.2.6 Арвайхээр хотод сууц өмчлөгчдийн холбоог тогтвортой байнгын үйл ажиллагаатай болгон нийтийн орон сууцнуудын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийлгэдэг болно.

4.2.7 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.

4.2.8 Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

4.2.9 Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ. Цахим өргөдөл, гомдлын 11-11 төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэдийн санал хүсэлт, гомдлыг тухай бүрд нь бүрэн шийдвэрлэж ажиллана.

4.2.10 Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод нээлттэй болгоно.



## ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

### 5.1. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

- 5.1.1 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын төв байгуулна.
- 5.1.2 Хужирт суманд үйл ажиллагаа явуулж буй бүх рашаан сувилалд цэвэршүүлэх байгууламж барина.
- 5.1.3 Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулна.
- 5.1.4 Өвөрхангай аймгийн хэмжээнд шаардлагатай бүс нутгуудад хөв цөөрөм байгуулна.
- 5.1.5 Усны хэрэглээ, хяналт, хэмнэлтийн бодлогыг бий болгож, менежментийг сайжруулна.
- 5.1.6 Хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, усны нөөцийг хуримтлуулах замаар говь тал, хээрийн нутгаа усаар хангах чиглэлээр ажиллана.
- 5.1.7 “Саарал” усыг дахин ашиглах, түүнд олгох урамшууллын тогтолцоог бий болгоно.
- 5.1.8 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
- 5.1.9 Цөлжилттэй тэмцэх шинэ технологийг нэвтрүүлж, энэ чиглэлээрх олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ.
- 5.1.10 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
- 5.1.11 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

### 5.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- 5.2.1 Утааг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологийг ашиглан дулаан, цахилгаан нийлүүлэх иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 5.2.2 Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулна.

